



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/94

Мандагловь

“Классик роуд” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/27 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн “Зураг төсөв боловсруулах” ажлын зардлаас “ШШГГ-аас баруун цагаан дэлгүүр хүртэлх 1,35км хатуу авто зам, явган хүний зам, гэрэлтүүлгийн ажлын зураг төсөв боловсруулах” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Классик роуд” ХХК-тай 36,700,000 (гучин зургаан сая долоон зуу) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2.Батлагдсан зургийн даалгаврын дагуу “ШШГГ-аас баруун цагаан дэлгүүр хүртэлх 1,5км хатуу авто зам, явган хүний зам, гэрэлтүүлгийн ажлын зураг төсөв боловсруулах” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Классик роуд” ХХК-ийн захирал (Ч.Төгсбат)-д үүрэг болгосугай.

3.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Л.ДОРЖБАТ



4822150708